

Хүзүүний архаг өвдөлтийг намдаах зүү булах эмчилгээний үр дүн

Ван Пинпин¹, У.Номин-Эрдэнэ¹, Ю.Оюунбилэг¹, Лун Фен³, Ч.Батнайрамдал², В.Энхтуяа^{1,2}

¹АШУУИС, МАУОУС, Зүү төөнө заслын тэнхим

²АШУУИС, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг

³БНХАУ, Гуйжоу Хотын Мэргэжлийн Дээд Сургууль

Цахим шуудан: btd24ee013@gt.mn.ums.edu.mn, Утас: 86898321

Түлхүүр үг:

Зүү эмчилгээ
Зүү булах
Хүзүүний архаг
өвдөлт
VAS
EQ-5D

Товч утга:

Үндэслэл: Компьютер, гар утас зэрэг технологийн дэвшлийг дагаад хүзүү, нурууны өвдөлт, бугуйн сувгийн хамшинж зэрэг нь өдөр тутмын амьдралд элбэг тохиолдох болсоныг цөөнгүй судалгаануудад дурдсан байна. **Зорилго:** хүзүүний архаг өвдөлтийн үед зүү булах аргын эмчилгээний үр дүнг тооцох. **Арга, аргачлал:** Судалгааг эмнэлзүйн туршилт судалгааны зэрэгцүүлсэн загвараар, дан нууцлалтай, санамсаргүй түүврийн аргаар эмчилгээний (n=40) болон хяналтын (n=40) бүлэгт хуваан хийж гүйцэтгэв. Судалгаанд хүзүүний архаг өвдөлттэй 80 эмчлүүлэгчийг хамруулсан бөгөөд үр дүнг 2 бүлэгт эмчилгээний өмнө болон дараа “Өвдөлтийн зэргийг тодорхойлох тоон шалгуурт үнэлэмж” (VAS), “Хүзүүний чадвар алдалтын индекс” (Neck disability index), “Хүзүүний өвдөлттэй хүмүүсийн амьдралын чанарыг үнэлэх асуумжаар” (EQ-5D) үнэлж тооцов. **Үр дүн:** Хүзүүний архаг өвдөлтийн үед зүү эмчилгээ болон зүү булах аргууд нь хүзүүний хөдөлгөөний далайцыг 2-5 хэмээр нэмэгдүүлж байна. Зүү булах арга нь хүзүүний өвдөлтийг стандарт зүү эмчилгээтэй ижил намдаах, хүзүүний чадвар алдалтын индексийг сайжруулж, хүзүүний архаг өвдөлттэй өвчтөний амьдралын чанарыг сайжруулж, ялангуяа сэтгэл гутрал, айдас түгшүүрийн оноог статистик ач холбогдолтойгоор бууруулж байна. **Дүгнэлт:** 1. Стандарт зүү эмчилгээ болон зүү булах эмчилгээ нь хүзүүний үений архаг өвдөлтийг намдаахад ижил үйлчилгээтэй байна. 2. Зүү булах арга нь энгийн зүү эмчилгээтэй харьцуулахад мөн адил хөдөлгөөний далайцыг нэмэгдүүлж байв. 3. Мөн зүү булах арга нь эмчлүүлэгчийн чадвар алдагдлын индексийг бууруулах, амьдралын чанарыг сайжруулах үйлдэлтэй байна.

Үндэслэл: Хүзүүний архаг өвдөлт (ХАӨ) нь амь насанд аюулгүй боловч амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, ажлын чадварыг алдагдуулдаг зонхилон тохиолдох эмгэг юм. Энэ өвчний үед өвдөлт нь хүзүү, толгой, гар уруу дамжих болох бөгөөд үүнд булчингийн, мэдрэлийн ёзоор дарагдлын, хүзүүний нугалам хоорондын үений буюу нугалмын дегенератив өөрчлөлт, шөрмөсний гаралтай өвдөлтүүд багтдаг байна.^{1,2}

Хүзүүний өвдөлтийг үүсгэх эрсдэлт хүчин зүйлд удаан хугацаагаар суух, стресстэй, хэт ачаалалтай ажиллах, сэтгэл гутрах, тамхи татах эсвэл урьд өмнө нь хүзүү болон мөрний гэмтэл авч байсан зэрэг нь нөлөөлдөг. Оффисын ажилтнууд өдөрт 6-8 цаг компьютерын дэлгэц ширтэх нь энгийн үзэгдэл

болсон төдийгүй насанд хүрэгчид хоногт 3-аас дээш цаг гар утсаа хэрэглэдэг байна. ХАӨ нь урт хугацаанд үргэлжилбэл тухайн хүний амьдралын чанар, сэтгэл санаа, нийгмийн оролцоо, ажил эрхлэлтийн түвшин болон орлогыг бууруулах сөрөг нөлөөтэй гэж судлаачид сүүлийн жилүүдэд нотлох болжээ.^{3,4}

Судлаач нар хүзүүний өвдөлт, түүнд нөлөөлөх ачаалал дарамтыг судлах олон улсын судалгаанд дурдсанаар 2020 оны байдлаар дэлхийд 203 сая хүн хүзүүний өвдөлттэй байгаа бөгөөд 2050 онд 269 сая болж 32.5%-иар өснө гэжээ. Энэ өвчний эмчилгээнд өвдөлт намдаах эмийн эмчилгээ, стероид тарилга, булчин сулруулагч эмүүдийг зөвлөхөөс гадна физик эмчилгээ, татлага, зөөлөн иллэг, зүү эмчилгээ зэргийг санал болгодог байна.⁵

НИН буюу АНУ-ын эрүүл мэндийн хүрээлэнгийн уламжлалт болон Нэгдмэл анагаах ухааны хүрээлэнгийн мэдээлснээр зүү эмчилгээ нь хүзүүний өвдөлтийн үед хавсран хэрэглэх эмчилгээний үр дүнтэй аргад тооцогддог. Зүү булах эмчилгээ буюу Acupoint catgut-embedding эмчилгээ нь 1960-аад оноос эмнэлзүйн практикт нэвтэрч байгаа эмчилгээний арга бөгөөд мэс заслын утсыг тодорхой урттай сонгон авч тусгай зүү ашиглан хүний биеийн зүүний сүвд буюу эд эсэд булснаар хий, цусны үйл ажиллагааг зохицуулах, арга билгийн тэнцвэрийг хангах, бие махбодын өвчин эсэргүүцэх чадварыг сайжруулах энгийн зүү эмчилгээний зарчимд тулгуурлан, бие махбодод гаднын биетийг үлдээснээр цочроох хугацааг уртасгасан, зүү эмчилгээний бусад аргуудтай харьцуулахад эмчлүүлэгчийн цагийг хэмнэсэн, өвдөлт намдаах үр дүнтэй аргад тооцогддог байна.^{6,7}

Иймд бид хүзүүний архаг өвдөлтийн эмнэлзүйн судалгаа цөөнгүй хийгдсэн ч зүү булах эмчилгээний үр дүнг тооцож, нотолгоожуулсан судалгаа хийгдээгүй нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Хүзүүний архаг өвдөлтийн үед зүү булах эмчилгээний өвдөлтийг намдаах үр дүнг судлах

Арга, аргачлал: Судалгаанд эмнэлзүйн туршилт судалгааны зэрэгцүүлсэн загварыг дан нууцлалтайгаар ашиглан, хүзүүний архаг өвдөлттэй 80 хүнийг хамруулж, санамсаргүй түүврийн аргаар эмчилгээний (n=40) болон хяналтын (n=40) бүлэгт хуваан хийж гүйцэтгэв. Үр дүнг 2 бүлэгт эмчилгээний өмнө болон дараа “Өвдөлтийн зэргийг тодорхойлох тоон шалгуурт үнэлэмж” (VAS), “Хүзүүний чадвар алдалтын индекс” (Neck disability index), “Хүзүүний өвдөлттэй хүмүүсийн

амьдралын чанарыг үнэлэх асуумжаар” (EQ-5D) үнэлж тооцов. Эмчилгээний бүлэгт эмчилгээний 1 болон 10 дахь хоногт хүзүүний *Jiaji* (EX-B2), *Jianjing* (GB 21) болон *Ashi* сүвүүдэд 1 см урттай эмчилгээний утсыг сонгон авч хэсэг газрын халдваргүйжүүлэлтийг сайтар хийсний дараа хатган утсыг суулгасан. Хяналтын бүлэгт эмчилгээний 1-10 хоногуудад дээрхтэй ижил жороор зохих журмын дагуу зүү тавьж эмчилгээ хийв. Эмчилгээний үр дүнг эмчилгээний 1 дэх болон 30 дахь хоногт судалгаанд хамрагдагсдын хүзүүний өвдөлтийн зэрэг, хүзүүний үений далайц, амьдралын чанарыг асуумжийг тус тус авч бүлэг хоорондыг SPSS 23.0 программыг ашиглан t-test-ээр харьцуулан тооцов. Судалгааны ёс зүйн зөвшөөрлийг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2024 оны 1-р сарын 19-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж зөвшөөрөл авсан болно (№24/19/01).

Үр дүн: Судалгааны үр дүнг тооцоход хүзүүний үений далайцыг үнэлэх болон өвдөлт намдаах, чадвар алдалтыг бууруулах, амьдралын чанарт үзүүлэх нөлөөг судалгаанд хамрагдагсад өөрөө үнэлэх стандарт хэрэглэгдэхүүнийг ашиглан тус тус үнэлсэн ба эмчилгээний эхний өдөр үнэлгээний хувьд 2 бүлэг хооронд статистикийн хувьд ялгаа ажиглагдсангүй.

Хүзүүний үений далайцыг гониометрийг ашиглан стандартын дагуу хэмжсэн. Үүнд бид эмчилгээний дараа эмчилгээний бүлэгт тонгойх хөдөлгөөн 5.33°, гэдийх хөдөлгөөн 4.13°, зүүн баруун тийш эргүүлэх хөдөлгөөн 5.23-5.28°-ээр нэмэгдсэн нь хяналтын бүлэгтэй харьцуулахад 0.93-1.93°-ээр илүү, ялангуяа тонгойх, баруун зүүн тийш эргүүлэх хөдөлгөөний далайцын өөрчлөлт нь статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай байлаа (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хүзүүний үений далайцыг 2 бүлэгт эмчилгээний өмнө ба дараа харьцуулсан нь

Хүзүүний хөдөлгөөн	Хугацаа	Эмчилгээний бүлэг (n=40)	Харьцуулах бүлэг (n=40)	t-тест	p-утга
Тонгойх	Өмнө	37.80±2.52	37.78±2.26	0.047	0.963
	Дараа	42.33±2.65	41.18±2.45	2.014	0.047
Гэдийх	Өмнө	38.85±1.99	39.15±2.80	-0.552	0.582
	Дараа	42.98±2.80	42.35±2.26	1.099	0.275
Зүүн эргүүлэх	Өмнө	48.70±3.61	48.30±2.83	0.551	0.583
	Дараа	53.98±2.35	52.00±2.06	3.997	0.000
Баруун эргүүлэх	Өмнө	48.60±3.53	48.30±2.83	0.419	0.676
	Дараа	53.93±2.13	51.78±2.02	4.634	0.000
Зүүн нугалах	Өмнө	40.08±2.97	39.88±2.95	0.302	0.763
	Дараа	42.48±2.89	42.13±2.55	0.574	0.568
Баруун нугалах	Өмнө	40.03±2.89	39.58±2.99	0.685	0.495
	Дараа	42.43±2.72	41.85±2.68	0.952	0.344

Хүзүүний өвдөлтийг VAS оноогоор үнэлэхэд эмчилгээний дараа хоёр бүлэгт 5 оноогоор буурсан нь стандарт зүү эмчилгээ болон зүү булах эмчилгээний

хоёр аргууд бүгд өвдөлт намдаах үйлдэлтэйг харуулж байна (Хүснэгт 2).

**Хүснэгт 2. Хүзүүний өвдөлтийг
VAS оноогоор 2 бүлгийг
харьцуулсан байдал**

Бүлэг	Тоо	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа
Эмчилгээний бүлэг	40	7.78±0.83	1.93±1.46
Харьцуулах бүлэг	40	7.85±0.66	2.20±1.40
t-тест		-0.45	-0.86
p-утга		0.66	0.39

**Хүснэгт 3. Хүзүүний чадвар алдалт (Neck Disability Index)-ын асуумжийн үнэлгээний дүнг 2 бүлэгт
харьцуулсан байдал**

Бүлэг	Тоо	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа
Эмчилгээний бүлэг	40	31.68±8.05	11.1±10.34
Харьцуулах бүлэг	40	31.4±7.99	12.82±8.84
t-тест		0.15	-0.8
p-утга		0.88	0.43

Мөн Neck Disability Index буюу архаг хүзүүний өвдөлт нь өдөр тутмын амьралаа зохицуулах чадварт хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох асуумж бөгөөд энэ нь эмчилгээний дараа 2 бүлэгт 18.58-20.58 оноогоор буурсан бөгөөд энгийн зүү эмчилгээнээс зүү булах эмчилгээний арга нь илүү үр дүнтэй байгаа нь харагдаж байна (Хүснэгт 3).

5 асуулгатай амьдралын чанарыг тодорхойлох асуумжийн (EQ-5D) үнэлгээний үр дүн нь 2 бүлэгт эмчилгээний дараа бүгд илэрхий сайжирсан бөгөөд сэтгэл гутрал болон айдас түгшүүрээс бусад бүх үзүүлэлт статистик ач холбогдолгүй байлаа (Хүснэгт 4).

**Хүснэгт 4. EQ-5D амьдралын чанарыг тодорхойлох асуумжийн
үнэлгээний дүнг 2 бүлэгт харьцуулсан байдал**

Асуумжууд	Хугацаа	Эмчилгээний бүлэг (n=40)	Харьцуулах бүлэг (n=40)	t-тест	p-утга
Өөртөө анхаарал халамж тавих	Өмнө	3.13±0.40	3.00±0.51	1.22	0.22
	Дараа	1.28±0.45	1.33±0.47	-0.48	0.63
Ердийн үйл ажиллагааны байдал	Өмнө	3.08±0.80	3.03±0.92	0.26	0.79
	Дараа	1.25±0.44	1.28±0.45	-0.25	0.80
Хөдөлгөөн	Өмнө	3.05±0.71	2.95±0.45	0.75	0.46
	Дараа	1.20±0.41	1.28±0.45	-0.78	0.44
Өвдөлт болон тавгүй байдал	Өмнө	3.28±0.88	3.15±0.92	0.08	0.94
	Дараа	1.43±0.59	1.55±0.55	-1.08	0.29
Сэтгэл гутрал болон айдас түгшүүр	Өмнө	3.33±1.42	3.30±1.54	0.23	0.82
	Дараа	1.43±0.68	1.60±0.78	-4.56	0.00
VAS-өвдөлтийн оноо	Өмнө	81.9±6.83	81.55±6.80	0.23	0.82
	Дараа	9.98±7.94	16.68±4.82	-4.56	0.00

Хэлцэмж: Хүзүүний архаг өвдөлт нь 3 сараас дээш хугацаанаас дээш үргэлжлэх байнгын зовиуртай, өвдөлттэй, амьралын чанар болон тухайн хүний эдийн засагт сөргөөр нөлөөлдөг хүчин зүйл бөгөөд хүзүүний цочмог өвдөлтийн 85% нь архагшдаг байна.⁸ ХАӨ нь дэлхийн хүн амд 10-30% нь өвдөж байсан гэсэн тооцоо гарсан бол 2017 онд 288 сая тохиолдол бүртгэгдсэн нь энэ өвчлөл маш өндөр тархалттай байгааг харуулж байна.⁹⁻¹⁰ Тус өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлийг судлахад бие махбодын талаас илрэх зовиураас гадна сэтгэлзүйн байдал, хүзүүний өвдөлт архагшихаар үений далайц, ачаалал даах чадварт сөргөөр нөлөөлж амьдралын чанар, ерөнхий сэтгэлзүйн байдлыг дарангуйлж сэтгэл гутрал, түгшилд хүргэдэг байна.¹¹⁻¹² Ялангуяа эмэгтэйчүүдэд боловсролын түвшин, хүзүүний анхдагч өвдөлтийн зэрэг нь шууд хамааралтайгаас гадна нойрны чанар мууддаг нь тогтоогдсон байна.¹³⁻¹⁴ Техник технологийн дэвшилтэй холбоотойгоор “Tech neck” нэр томъёо шинээр хэрэглэгдэх болж хүзүүний массажны тоног төхөөрөмжийн хэрэгцээ жилд 8.3%-иар өснө гэж зах зээлийн судалгааны байгууллагаас дүгнэжээ.¹⁵

Хүзүүний өвдөлтийн үеийн зүү эмчилгээний тухай судалгаанууд Pubmed мэдээллийн санд хайлт хийхэд нийт 821 судалгаа гарч ирсний 282 нь сүүлийн 5 жилд хийгдсэн байна. 2024 онд хийгдсэн 2593 хүнийг хамруулсан, 14 төрлийн зүү эмчилгээний аргуудыг харьцуулсан 28 хүзүүний архаг өвдөлтийн үеийн зүү эмчилгээний аргуудыг харьцуулсан мета-анализ судалгаанд зүү булах эмчилгээ нь хүзүүний өвдөлтийг хамгийн хурдан бөгөөд үр дүнтэйгээр бууруулж байгааг нотолгоожуулсан байна.¹⁶

Бид хүзүүний архаг өвдөлтийн үед хэрэглэгддэг стандарт зүү эмчилгээний аргыг зүүний сүвд утас суулгах буюу зүү булах аргатай харьцуулан эмч болон эмчлүүлэгчийн өөрийн үнэлгээнд тулгуурлан үр дүнг харьцуулан үзлээ. Зүү булах эмчилгээ нь энгийн зүү эмчилгээний зарчимд тулгуурлан боловсруулсан эмчилгээний шинэ арга бөгөөд эмчлүүлэгчийн эмнэлэгт зарцуулах цагийг багасгасан, өвдөлтийг намдаах үр дүнтэй эмчилгээний арга гэж үзэн сүүлийн жилүүдэд судлаач нар түлхүү судлах болсон.¹⁷⁻¹⁹

Бидний судалгаагаар стандарт зүү эмчилгээ болон зүү булах эмчилгээ нь хүзүүний өвдөлтийг

намдаах, хүзүүний үе болон хөдөлгөөний далайцыг нэмэгдүүлэх, чадвар алдагдлын индексийг бууруулах, үйлчлүүлэгчийн амьдралын чанарыг сайжруулах үйлдэлтэй байгаа нь ажиглагдлаа.²⁰ Ялангуяа зүү булаах арга нь зарим тохиолдолд стандарт зүү эмчилгээнээс илүү үр дүнтэй байсан нь БНСУ-ын Сөүл хотын Догтук Их Сургуулийн Зүү төөнө заслын тэнхимийн судлаач Жо нарын судалгааны үр дүнтэй дүйж байна.²¹

Дүгнэлт: Хүзүүний архаг өвдөлтийн үед зүү эмчилгээ болон зүү булаах аргууд нь хүзүүний хөдөлгөөний далайцыг 2-5 хэмээр нэмэгдүүлж байсан ба зүү булаах арга нь стандарт зүү эмчилгээтэй ижил үр дүн үзүүлсэн бөгөөд тонгойх болон зүүн баруун тийш хазайлгах хөдөлгөөний далайцыг нэмэгдүүлэх нь статистик ач холбогдолтой байлаа.

Зүү булаах арга нь хүзүүний өвдөлтийг стандарт зүү эмчилгээтэй ижил намдаах, хүзүүний чадвар алдалтын индексийг сайжруулах болон хүзүүний архаг өвдөлттэй өвчтөний амьдралын чанарыг сайжруулах, ялангуяа сэтгэл гутрал болон айдас түгшүүрийн оноог статистик ач холбогдолтойгоор бууруулж байна.

Ном зүй:

1. Cate P, Cassidy JD, Carroll L. The Saskatchewan Health and Back Pain Survey. The prevalence of neck pain and related disability in Saskatchewan adults. *Spine* 1998;23(15):1689-98
2. Hogg-Johnson S, van der Velde G, Carroll LJ, Holm LW, Cassidy JD, Guzman J, et al. The burden and determinants of neck pain in the general population: results of the Bone and Joint Decade 2000-2010 Task Force on Neck Pain and Its Associated Disorders. *Spine* 2008;33(4S):S39-51.
3. Borenstein DG. Management of neck pain: a primary care approach. *Hosp Pract* 98;33:147-50. 153-4, 160.
4. Field T. Massage therapy. *Med Clin North Am* 2002, 86:163.
5. Global, regional, and national burden of neck pain, 1990-2020, and projections to 2050: a systematic analysis of the Global Burden of Disease Study 2021 <https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC10897950/>
6. Jo, Hyo-Rim KMD, BSca; Noh, Eun-Ji KMD, BSca; Oh, Se-Hee KMD; Choi, Seong-Kyeong KMD, BSca; Sung, Won-Suk KMD, PhD; Choi, Su-Ji KMD, PhD; Kim, Dong-Il KMD, PhD; Hong, Seung-Ug KMD, PhD; Kim, Eun-Jung KMD, PhD;*. Comparative effectiveness of different acupuncture therapies for neck pain. *Medicine* 101(33):p e29656, August 19, 2022. DOI: 10.1097/MD.00000000000029656
7. Ren XY. Discussion on the origin and mechanism of acupoint em-
8. bedding. *Zhong Guo Yi Yao Xue Bao* 2004; 19: 757-9.
8. Hoy DG, Protani M, De R, Buchbinder R. The epidemiology of neck pain. *Best Pract Res Clin Rheumatol*. 2010;24(6):783-92. doi: 10.1016/j.berh.2011.01.019.
9. Goode AP, Freburger J, Carey T. Prevalence, practice patterns, and evidence for chronic neck pain. *Arthritis Care Res (Hoboken)*. 2010;62(11):1594-601. doi: 10.1002/acr.20270.
10. Fejer R, Kyvik KO, Hartvigsen J. The prevalence of neck pain in the world population: a systematic critical review of the literature. *Eur Spine J*. 2006;15(6):834-48. doi: 10.1007/s00586-004-0864-4.
11. Shahidi B, Curran-Everett D, Mahuf KS. Psychosocial, Physical, and Neurophysiological Risk Factors for Chronic Neck Pain: A Prospective Inception Cohort Study. *J Pain*. 2015;16(12):1288-99. doi: 10.1016/j.jpain.2015.09.002.
12. Kim R, Wiest C, Clark K, Cook C, Horn M. Identifying risk factors for first-episode neck pain: A systematic review. *Musculoskelet Sci Pract*. 2018;33:77-83. doi: 10.1016/j.msksp.2017.11.007.
13. Hendriks EJM, Scholten-Peeters GGM, van der Windt D, Neeleman-van der Steen CWM, Oostendorp RAB, Verhagen AP. Prognostic factors for poor recovery in acute whiplash patients. *Pain*. 2005;114(3):408-16. doi: 10.1016/j.pain.2005.01.006.
14. Ris I, Barbero M, Falla D, Larsen MH, Kraft MN, Sogaard K, et al. Pain extent is more strongly associated with disability, psychological factors, and neck muscle function in people with non-traumatic versus traumatic chronic neck pain: a cross sectional study. *Eur J Phys Rehabil Med*. 2019;55(1):71-8. doi: 10.23736/S1973-9087.18.04977-8.
15. Mayo clinic <https://www.mayoclinic.org/diseases-conditions/neck-pain/diagnosis-treatment/drc-20375587>
16. Lin Y, Zhong S, Huang C, Zhang G, Jiang G. The efficacy of acupuncture therapies in cervical spondylotic radiculopathy: A network meta-analysis. *Heliyon*. 2024 May 27;10(11):e31793. doi: 10.1016/j.heliyon.2024.e31793. PMID: 38912448; PMCID: PMC11190544.
17. Feng H., Jiang Y., Ding M., et al. Comparative study on adverse effects on patients with cervical spondylosis with embedding by different materials. *J Nanjing Univ Tradit Chin Med*. 2012;5:26.
18. Li R., Wang B., Sun L., et al. The curative effect of acupoint catgut-embedding in treating cervical spondylotic radiculopathy. *Modern Journal of Integrated Traditional Chinese and Western Medicine*. 2015;24(33):3685-3687
19. Feng H., Jiang Y., Ding M., et al. Comparative study on adverse effects on patients with cervical spondylosis with embedding by different materials. *J Nanjing Univ Tradit Chin Med*. 2012;5:26.
20. Amnon A Berger., et al. Efficacy of Dry Needling and Acupuncture in the Treatment of Neck Pain, *Anesth Pain Med*, . 2021 Apr; 3;11(2):e113627. doi: 10.5812/aapm.113627
21. Hyo-Rim Jo., et al. Comparative effectiveness of different acupuncture therapies for neck pain, Meta analysis, 2022 Aug 19;101(33):e29656. doi: 10.1097/MD.00000000000029656.

The effectiveness of acupoint catgut embedding treatment for chronic neck pain

Pingping Wang¹, Nomin-Erdene U¹, Oyunbileg Yu¹, Feng Lu³, Batnairamdal Ch², Enkhtuya V^{1,2}

¹MNUMS, ISMM, Department of Acupuncture and Moxibustion

²MNUMS, Central Hospital of Mongolian Traditional Medicine

³P.R.China, Guizhou City Vocational College

E-mail: btd24ee013@gt.mnums.edu.mn, Tel: +976-86898321

Background: Numerous studies have shown that with the advancement of technology such as computers and cell phones, neck and back pain, and carpal tunnel syndrome have become common in daily life.

Aim: Estimating the effectiveness of acupoint catgut embedding treatment for chronic neck pain. **Materials and Methods:** The study used a randomized clinical trial, double-blind, placebo-controlled design with treatment (n=40) and control (n=40) groups. The study included 80 patients with chronic neck pain, and the results were evaluated in the two groups before and after treatment using the “Visual Analogue Scale (VAS)”, “Neck Disability Index”, and “Quality of Life Questionnaire” (EQ-5D).

Results: Acupoint catgut embedding and acupuncture treatment for chronic neck pain increased the neck’s range of motion by 2-5 degrees. Standard acupuncture treatment and acupoint catgut embedding treatment reduce neck pain and improve the neck disability index. Acupoint catgut embedding treatment improves the quality of life of patients with chronic neck pain, especially reducing anxiety and fear scores with statistical significance.

Conclusion:

1. Standard acupuncture and acupoint catgut embedding treatment are equally effective in relieving chronic neck pain.
2. Acupoint catgut embedding treatment increased the range of motion in the same way as standard acupuncture.
3. Acupoint catgut embedding treatment also reduced the patient’s Neck Disability Index and improved Quality of life.

Keywords: Acupuncture treatment, Acupoint catgut embedding treatment, Chronic neck pain, VAS, EQ-5D